

“ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА ”

ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 1. Ерөнхий мэдээлэл** “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулах, мэдээллийн бааз үүсгэх ажлыг захиалагчийн мэргэжил, арга зүйн удирдлага, хяналт дор гүйцэтгэх
- 2. Зөвлөхийг сонгох ажиллагаа** Зөвлөх үйлчилгээний зарлалыг 2018 оны 03 дугаар сарын 30-нд “Өдрийн сонин”-д нийтлүүлсэн ба 4 байгууллага санал ирүүлсэн бөгөөд эдгээр 4 байгууллагыг хураангуй жагсаалтанд оруулан тендерийн урилга хүргүүлсэн. Урилга хүргүүлсэн байгууллагуудаас 3 байгууллага тендер ирүүлсэн.
- 3. Техникийн саналын үнэлгээ** “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтанд “Стратеги академи”, “IRIM “ ХХК болон “MIRIM” ХХК-ийн түншлэл, “SICA”ХХК-ууд 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10 цагаас өмнө тус тус материалаа ирүүлсэн бөгөөд “ММСГ” ХХК тендерээ ирүүлээгүй болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгаа институтийн захирлын 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/01 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо 100% ирцтэйгээр 2018 оны 6 дугаар сарын 04-ны өдөр техникийн саналын үнэлгээг хийж гүйцэтгэв. Үнэлгээнд “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”, “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг тус тус мөрдлөг болгон ажиллалаа.

ТББ-ийн ТӨХ-ийн 1.1-д зааснаар Чанарын үнэлгээний аргаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.3 зүйлд зааснаар техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж, тухайн зөвлөхтэй санхүүгийн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох хэлэлцээр хийх зарчмаар зохион байгуулж явууллаа..

Үнэлгээний хорооны үнэлгээгээр техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан “SICA” ХХК-тай санхүүгийн санал болон бусад нөхцлийг тохиролцсоны үндсэнд “Хөдөлмөрийн зах зэлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олголоо.